



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2024/17/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.02.23 № 103
танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Б.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Аймаг, сумдын орон нутгийн төсвөөс 889.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийг соён гэгээрүүлэх, иргэд олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахад 215.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.

Аудитын гол асуудал

Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасагт ахлах нягтлан бодогч 1, нягтлан бодогч 1, нярав 1 орон тоогоор батлагдан төвдөө байрлаж ажилладаг бөгөөд Цогтцэций сумын Сум дундын цагдаагийн хэлтэс, Гашуун сухайт дахь гэрээт цагдаагийн хэлтэс, Ханбогд, Гурвантэс сум дахь цагдаагийн тасгуудад талбарт дээр хүрч ажиллах боломжгүй байгаа нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт сулрах, хөрөнгө дутагдах, үрэгдэх, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл учирах эрсдэлийг бий болгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Өмнөговь аймаг, Цогтцэций сумын Таван толгойн бүлэг ордоос Гашуун сухайт хүртэлх 239 км автозам болон Цагаан хад суурьшлын бүсийн нийгмийн хэв журмыг хангуулах, гэрээт цагдаагийн нэгж ажиллуулах тухай Цагдаагийн Ерөнхий газар, "Эрдэнэс

016020327

Монгол” ХХК, “Гашуун сухайт авто зам” ХХК-тай байгуулсан гэрээт ажлын төсөв хүрэлцээгүйгээс 97.6 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	453,380,867.38	710,583,703.11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	17,668,168.25	64,233,168.25
312	Банканд байгаа бэлэн мөнгө	17,668,168.25	64,233,168.25
3121	Төгрөг	17,668,168.25	64,233,168.25
31211	Төрийн сангийн харилцах	17,668,168.25	64,233,168.25
33	АВЛАГА	00.00	97,612,871.50
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	97,612,871.50
35	БАРАА МАТЕРИАЛ	435,712,699.13	548,737,663.36
351	Түүхий эд материал	285,594,712.04	361,455,906.28
35110	Тусгай зориулалттай материал	276,512,660.04	359,325,904.28
35130	Эм боох материал	9,082,052.00	2,130,002.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	8,971,400.00	13,059,000.00
354	Хангамжийн материал	138,946,587.09	172,022,757.08
35410	Бичиг хэргийн материал	15,830,973.58	12,364,647.58
35420	Аж ахуйн материал	21,476,194.00	20,749,372.00
35440	Түлш, шатах тослох материал	4,005,733.01	857,910.00
35450	Барилгын засварын материал	3,372,110.00	3,526,110.00
35460	Хүнсний материал	8,225,232.00	165,000.00
35470	Бусад хангамжийн материал	86,036,344.50	131,369,717.50
35600	Мал амьтад	2,200,000.00	2,200,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,792,199,529.99	6,454,212,308.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,792,199,529.99	6,454,212,308.04
392	Биет хөрөнгө	6,162,710,529.95	5,826,693,307.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,088,635,662.47	4,302,412,631.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	-390,259,134.86	-512,061,114.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,237,491,722.92	1,121,301,722.56
39204	Хуримтлагдсан элэгдэл	-492,751,266.01	-475,439,717.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,303,687,355.28	1,984,139,837.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	-762,909,042.87	-767,140,378.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	163,011,509.60	172,451,185.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-65,882,196.72	-69,397,841.87
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	56,478,600.00	56,478,600.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-2,759,640.14	-2,759,640.14
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,053,775.68	22,157,110.68
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,086,815.40	-5,449,087.20
393	Биет бус хөрөнгө	629,489,000.04	629,489,000.04
39301	Програм хангамж	24,060,000.00	22,030,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-8,059,999.96	-7,999,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	613,489,000.00	613,489,000.00

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,245,580,397.37	7,164,796,011.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	97,612,871.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	97,612,871.50
413	Өглөг	00.00	97,612,871.50
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	26,353,229.25
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	42,717,242.25
4136	Бусад өглөг	00.00	28,542,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	28,542,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,245,580,397.37	7,067,183,139.65
51	Засгийн газрын хувь оролцоо	7,245,580,397.37	7,067,183,139.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,289,846,319.69	2,289,846,319.69
51101	Өмч: - төрийн	2,289,846,319.69	2,289,846,319.69
512	Хуримтлагдсан үр дүн	4,296,722,943.74	4,118,325,686.02
51210	Өмнөх үеийн үр дүн	4,296,722,943.74	4,296,722,943.74
51220	Тайлант үеийн үр дүн		-178,397,257.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	659,011,133.94	659,011,133.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,245,580,397.37	7,164,796,011.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,150,197,082.99	10,027,571,941.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,869,533,789.99	1,888,992,614.73
120	Нийтлэг татварын бус орлого	1,869,533,789.99	1,888,992,614.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,389,422,964.99	914,138,114.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,824,172.00	92,022,318.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,801,200.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,311,797,592.99	822,115,796.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,280,663,293.00	8,138,579,326.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,129,401,700.00	5,129,743,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,129,401,700.00	5,129,743,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,151,261,593.00	3,008,835,826.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	466,698,317.00	1,591,642,533.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,836,651.00	430,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	673,726,625.00	1,416,763,293.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,143,755,027.55	10,205,969,198.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,143,755,027.55	10,205,969,198.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,023,487,908.55	8,770,909,198.95

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,482,614,995.79	5,448,056,535.89
210101	Үндсэн цалин	2,255,696,762.79	2,583,161,443.05
210102	Нэмэгдэл	874,205,347.00	1,682,994,172.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,655,440.00	62,266,820.00
210104	Урамшуулал	119,045,573.00	157,492,121.00
210105	Гэрээт ажлын хөлс	208,011,873.00	962,141,979.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,033,795.08	152,246,143.00
210201	Тэтгэврийн даатгал	30,608,997.44	50,027,429.00
210202	Тэтгэмжийн даатгал	221,000.97	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	176,801.57	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	41,194.40	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	62,985,800.70	102,218,714.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,728,747.03	240,393,365.51
210301	Гэрэл, цахилгаан	39,311,369.53	55,188,673.01
210302	Түлш, халаалт	90,368,987.50	150,790,236.50
210303	Цэвэр, бохир ус	20,048,390.00	34,414,456.00
2104	Хангамж, бараа материалын зардал	287,296,526.54	338,337,622.85
210401	Бичиг хэрэг	28,847,350.00	16,820,934.00
210402	Тээвэр, шатахуун	192,586,358.50	290,692,889.51
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,299,200.00	18,727,927.34
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	228,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,934,869.00	11,975,872.00
210408	Бараа материал акталсны зардал	33,400,749.04	00.00
2105	Нормативд зардал	33,833,078.00	354,898,332.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,305,300.00	32,332,300.00
210502	Хоол, хүнс	25,151,778.00	310,271,032.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,376,000.00	12,295,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	69,435,200.00	49,644,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,983,440.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,761,960.00	104,500.00
210604	Урсгал засвар	62,689,800.00	49,540,200.00
2107	Томилолт, зочны зардал	31,987,400.00	31,987,400.00
210702	Дотоод албан томилолт	31,987,400.00	14,954,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,158,946.00	70,119,752.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,681,999.00	56,961,444.55
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,779,616.00	2,440,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	970,000.00	679,005.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	00.00	4,000,000.00
210807	Газрын төлбөр	1,326,800.00	5,417,087.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	400,531.00	621,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	793,399,220.11	2,102,258,925.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,667,240.00	389,977,290.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,387,005.94	12,342,538.20

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	775,344,974.17	1,699,939,097.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,267,119.00	1,435,059,821.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,473,544.00	1,372,954,649.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,430,000.00	4,773,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	50,860,132.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан алба хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	203,312,203.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	83,043,544.00	1,114,009,314.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,793,575.00	62,105,172.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,063,540.00	57,730,572.71
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг/нэмэлт санхүүжилт/	24,730,035.00	4,374,599.60
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,006,442,055.44	-178,397,257.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,720,000.28	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	13,720,000.28	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-13,720,000.28	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	992,722,055.16	-178,397,257.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,468,087,026.25	8,190,388,773.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,462,340.25	149,422,318.00
120	Нийтлэг татварын бус орлого	91,462,340.25	149,422,318.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	91,462,340.25	149,422,318.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,824,172.00	92,022,318.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,638,168.25	57,400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,376,624,686.00	8,040,966,455.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,129,401,700.00	5,129,743,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,129,401,700.00	5,129,743,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,247,222,986.00	2,911,222,955.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	466,698,317.00	1,591,642,533.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	10,836,651.00	430,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	769,688,018.00	1,319,150,422.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	4,413,125,758.00	8,108,428,373.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,413,125,758.00	8,108,428,373.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,282,458,339.00	6,673,368,551.69
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,540,874,018.00	5,480,991,215.64

210101	Үндсэн цалин	2,112,617,011.00	2,586,783,343.05
210102	Нэмэгдэл	1,075,544,121.00	1,682,994,172.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,655,440.00	62,266,820.00
210104	Үр дүнгийн урамшуулал	119,045,573.00	157,492,121.00
210105	Гэрээт ажлын хөлс	208,011,873.00	991,454,759.50
2102	Ажил ологчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,321,690.00	150,358,234.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	31,896,892.36	50,027,429.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	221,000.97	-
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	176,801.57	-
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	41,194.40	-
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	62,985,800.70	100,330,805.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	149,728,748.00	240,393,365.51
210301	Гэрэл цахилгааны зардал	39,311,370.50	55,188,673.01
210302	Түлш, халаалтын зардал	90,368,987.50	150,790,236.50
210303	Цэвэр, бохир усны зардал	20,048,390.00	34,414,456.00
2104	Хангамж, бараа материалын зардал	237,567,111.00	273,406,089.59
210401	Бичиг хэрэг	33,027,441.00	11,030,138.00
210402	Тээвэр, шатахуун	178,338,483.00	242,143,324.25
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,299,200.00	18,727,927.34
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	637,387.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,264,600.00	1,384,700.00
2105	Нормативд зардал	40,970,132.00	307,982,050.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,289,500.00	156,750.00
210502	Хоол, хүнс	33,612,632.00	291,827,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,068,000.00	15,998,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,703,400.00	74,903,900.00
210601	Багаж техник хэрэгсэл	6,165,440.00	20,843,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,602,460.00	376,200.00
210604	Урсгал засвар	64,935,500.00	53,684,200.00
2107	Томилолт, зочны зардал	31,987,400.00	14,954,000.00
210702	Дотоод албан томилолт	31,987,400.00	14,954,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	88,803,700.00	100,208,852.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	77,450,000.00	87,672,324.55
210804	Тээврийн хэрэгслийн татвар	8,009,500.00	2,440,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,017,400.00	679,005.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,000,000.00
210807	Газрын төлбөр	1,326,800.00	5,417,087.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,502,140.00	30,170,844.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,867,240.00	17,970,844.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,634,900.00	12,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130,667,419.00	1,435,059,821.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,873,844.00	1,372,954,649.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,830,000.00	4,773,000.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	50,860,132.00
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	203,312,203.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	83,043,844.00	1,114,009,314.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,793,575.00	62,105,172.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,063,540.00	57,730,572.71
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт санхүүжилт/	24,730,035.00	4,374,599.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	54,961,268.25	81,960,400.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	37,293,100.00	35,395,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,293,100.00	35,395,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	37,293,100.00	35,395,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,293,100.00	35,395,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(37,293,100.00)	(35,395,400.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	17,668,168.25	46,565,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	17,668,168.25
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,668,168.25	64,233,168.25

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,289,846,319.69	659,011,133.94	4,296,722,943.74	7,245,580,397.37
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,289,846,319.69	659,011,133.94	4,296,722,943.74	7,245,580,397.37
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-178,397,257.72	-178,397,257.72
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,289,846,319.69	659,011,133.94	4,118,325,686.02	7,067,183,139.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,188,239,400.00	5,164,035,245.29
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	5,188,239,400.00	5,164,035,245.29
210	Бараа, үйлчилгээний зардал	4,799,521,700.00	4,788,689,910.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,216,237,500.00	4,216,237,453.89
210101	Үндсэн цалин	1,676,660,300.00	2,134,626,132.80
210102	Нэмэгдэл	1,609,225,700.00	1,660,312,378.09
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	48,780,000.00	59,826,820.00
210104	Урамшуулал	106,037,000.00	157,492,121.00
210105	Гэрээт ажлын хөлс	775,534,500.00	203,980,002.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,119,500.00	84,661,699.00
210205	Эрүүл мэндийн даатгал	87,119,500.00	84,661,699.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	243,035,500.00	240,393,365.51
210301	Гэрэл цахилгаан	56,792,400.00	55,188,673.01
210302	Түлш, халаалт	149,157,300.00	150,790,236.50
210303	Цэвэр, бохир ус	37,085,800.00	34,414,456.00
2104	Хангамж, бараа материалын зардал	184,255,000.00	184,016,519.34
210401	Бичиг хэрэг	6,478,400.00	6,478,400.00
210402	Тээвэр (шатахуун)	157,512,600.00	157,365,492.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	18,575,700.00	18,667,927.34
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	303,600.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,384,700.00	1,384,700.00
2105	Нормативд зардал	6,731,300.00	6,708,050.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	180,000.00	156,750.00
210502	Хоол, хүнс	6,551,300.00	6,551,300.00
2106	Эд хогшил худалдан авах	21,954,200.00	21,906,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,300,000.00	8,275,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	400,000.00	376,200.00
210604	Урсгал засвар	13,254,200.00	13,254,200.00
2107	Томилолт, зочны зардал	10,320,500.00	10,278,000.00
210702	Дотоод албан томилолт	10,320,500.00	10,278,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	29,668,200.00	24,288,822.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,718,700.00	11,752,294.55
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,901,000.00	2,440,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,048,500.00	679,005.00
210806	Мэдээллийн технологийн зардал	4,000,000.00	4,000,000.00
210807	Газрын төлбөр	6,000,000.00	5,417,087.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	200,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	388,717,700.00	375,345,335.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	388,717,700.00	375,345,335.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,750,000.00	4,773,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,860,200.00	50,860,132.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	209,887,500.00	203,312,203.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	119,220,000.00	116,400,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,188,239,400.00	5,164,035,245.29
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,129,743,500.00	5,072,012,927.29

131001	Улсын төсвөөс санхүүжих	5,129,743,500.00	5,072,012,927.29
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	58,495,900.00	92,022,318.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,495,900.00	92,022,318.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,911,222,955.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,911,222,955.00
210	Бараа, үйлчилгээний зардал	1,915,509,041.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,264,753,761.75
210101	Үндсэн цалин	452,157,210.25
210102	Нэмэгдэл	22,681,794.00
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	2,440,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	787,474,757.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,696,535.00
210201	Тэтгэврийн даатгал	50,027,429.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,669,106.00
2104	Хангамж, бараа материалын зардал	89,389,570.25
210401	Бичиг хэрэг	4,551,738.00
210402	Тээвэр (шатахуун)	84,777,832.25
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	60,000.00
2105	Нормативд зардал	301,274,000.00
210502	Хоол, хүнс	285,276,000.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	15,998,000.00
2106	Эд хогшил худалдан авах	88,393,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,647,300.00
210602	Тавилга	8,316,000.00
210604	Урсгал засвар	40,430,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,676,000.00
210702	Дотоод албан томилолт	4,676,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	75,920,030.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,920,030.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	25,405,844.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,405,844.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,000,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	995,713,913.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	991,339,314.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	991,339,314.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,374,599.60
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	4,374,599.60
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,911,222,955.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,911,222,955.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,591,642,533.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	430,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,319,150,422.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд алдаа илрээгүй, аудитын явцад залруулга гараагүй байна.

Аудитаар нийт 20,478.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс уг зөрчилд хууль тогтоомж хэрэгжүүлж ажиллахтай холбоотой 20,478.0 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Тайлант онд төлбөрийн акт тогтоогдоогүй.

3.2 Албан шаардлага

Тайлант онд албан шаардлага гараагүй болно.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Илрүүлэлт: Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг тоолж, тооллогын үр дүнг тооцоогүй, агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2 “бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэглэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх”, 72 дугаар зүйлийн 72.1 “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.3 “агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах”-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, агуулахын эмх цэгц, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, өмнөх тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах, бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулж ажиллах

2. Илрүүлэлт: Гэрээт цагдаагийн нэгж ажиллуулах тухай Цагдаагийн Ерөнхий газар, “Эрдэнэс Монгол” ХХК, “Гашуун сухайт авто зам” ХХК-тай байгуулсан гэрээт ажлын төсөв хүрэлцээгүйгээс үүссэн 97,612.9 мянган төгрөгийн өглөгийг Эрдэнэс Монгол ХХК-аас авах авлагаар бүртгэсэн ч тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байгаа нь өр төлбөр төлөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдэх, төсвийг зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй байх, холбогдох эрх бүхий дээд шатны байгууллагад хандаж зөрчлийг арилгаж ажиллах

3. Илрүүлэлт: Аймгийн ТЕЗ-тай байгуулсан гэрээний хүрээнд орон нутгийн төсвөөс олгосон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ хариуцсан хэлтэс, тасгуудын зарцуулсан төсвийн хөрөнгөд байгууллагаас дотоод хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгаас төсөл хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд олгосон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан арга хэмжээний үр нөлөө, үр дүнг тооцож ажиллах

4. Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын 2023 оны А/2078 дугаар захирамжаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын “Урд бүсийн волейбол”-ын аварга шалгаруулах тэмцээнд 14,478.0 мянган төгрөг, Даланзадгад сумын ЗДТГ-ын даргын 2023 оны А/184 дүгээр тушаалаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Санта Цагдаа” арга хэмжээнд 6,000.0 мянган төгрөгийг тус тус санхүүгийн дэмжлэгээр авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн чиг үүрэг гүйцэтгэхтэй холбоогүйгээр төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулж, санхүүгийн дэмжлэг туслалцаа авахгүй байх

5. Илрүүлэлт: Цагдаагийн Ерөнхий газрын Захиргаа, удирдлагын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 5/276 дугаартай албан бичигт ирүүлсэн чиглэлийн дагуу 2023 оны ээлжийн амралтаа биеэр эдлээгүй, дутуу эдэлсэн 16 алба хаагчид үндсэн цалингийн 20-50 хүртэл хувиар мөнгөн урамшил олгосон байна.

Энэ нь Цагдаагийн албаны тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1 “Цагдаагийн алба хаагчид жил бүр ажлын 15 өдрийн үндсэн амралт олгож, биеэр эдлүүлнэ” 90.3 “Ажлын зайлшгүй шаардлагаар нэмэгдэл амралтаа биеэр бүрэн эдэлж чадаагүй цагдаагийн алба хаагчид түүний зөвшөөрснөөр хоногт ногдох цалинг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшил олгоно”-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдлээгүй, дутуу эдэлсэн цагдаагийн алба хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу мөнгөн урамшууллыг нөхөн олгох, зөрчлийг арилгах

6. Илрүүлэлт: Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 34,095.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэхдээ төрийн худалдан авах ажиллагааны газарт санал хүргүүлээгүй, бусад газраас худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухай жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 14.4 Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно”-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байх, захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн шийдвэрлүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг тоолж, тооллогын үр дүнг тооцоогүй, агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.	1	-					1	-				
Гэрээт цагдаагийн нэгж ажиллуулах тухай Цагдаагийн Ерөнхий газар, “Эрдэнэс Монгол” ХХК, “Гашуун сухайт авто зам” ХХК-тай байгуулсан гэрээт ажлын төсөв хүрэлцээгүйгээс үүссэн 97,612.9 мянган төгрөгийн өглөгийг Эрдэнэс Монгол ХХК-аас авах авлагаар бүртгэсэн ч тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй байгаа нь өр төлбөр төлөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэсэн байна.	1	-					1	-				
Аймгийн ТЕЗ-тай байгуулсан гэрээний хүрээнд орон нутгийн төсвөөс олгосон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ хариуцсан хэлтэс, тасгуудын зарцуулсан төсвийн хөрөнгөд байгууллагаас дотоод хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллаагүй байна.	1	-					1	-				
Аймгийн Засаг даргын 2023 оны А/2078 дугаар захирамжаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын “Урд бүсийн волейбол”-ын аварга шалгаруулах тэмцээнд 14,478.0 мянган төгрөг, Даланзадгад сумын ЗДТГ-ын даргын 2023 оны А/184 дүгээр тушаалаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Санта Цагдаа” арга хэмжээнд 6,000.0 мянган төгрөгийг тус тус санхүүгийн дэмжлэг авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	20,478.0					1	20,478.0				

Цагдаагийн Ерөнхий газрын Захиргаа, удирдлагын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 5/276 дугаартай албан бичигт ирүүлсэн чиглэлийн дагуу 2023 оны ээлжийн амралтаа биеэр эдлээгүй, дутуу эдэлсэн 16 алба хаагчид үндсэн цалингийн 20-50 хүртэл хувиар мөнгөн урамшил олгосон байна.	1	-				1	-			
Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 34,095,400 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэхдээ цахим дэлгүүр санал хүргүүлээгүй, бусад газраас худалдан авсан байна.	1					1				
ДҮН	6	20,478.0				1	20,478.0			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны сайтад дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн, төсвийн гүйцэтгэлийн мэдээний түүний хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг оруулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн зарлагын /төвлөрүүлсэн шилжүүлэг/ 51,438.8 мянган төгрөгийн 3 ажил гүйлгээг тус тус мэдээлээгүй байна	1	51,438.8					1	51,438.8	
Дүн	1	51,438.8	-	-	-	-	1	51,438.8	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчлүү й	Хязгаарл алттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзса н
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулс ан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
НИЙТ									

